


# САНГИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## (2024 оны 11 дүгээр сар)

Яамны газруудын 2024 оны 11 дүгээр сарын үйл ажиллагааны биелэлтийг “**Яамны дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам**”-д заасан дараах 5 шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд үнэлгээний дундаж 98.5 хувьтай байлаа.

**98.7%**
Сарын төлөвлөгөө
**24.7 оноо**

**99.2%**
Албан бичгийн шийдвэрлэлт
**9.9 оноо**

**100.0%**
Шуурхай үүрэг даалгавар
**5.0 оноо**

**95.2%**
Ажлын цаг ашиглалт
**9.5 оноо**

**100.0%**
Үйл ажиллагааны ил тод нээлттэй байдал
**10.0 оноо**

### Газруудын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ /2024.11/

| № | Газар | Сарын төлөвлөгөө | Албан бичгийн шийдвэрлэлт | Ш/ү даалгаврын хэрэгжилт | Цаг ашиглалт | Ү/а-ны ил тод нээлттэй байдал | Нийт | | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Авсан оноо | Авсан оноо | Авсан оноо | Авсан оноо | Авсан оноо | Нийт авах | Авсан оноо | |
| 1 | ТБТГ | 25.0 | 9.9 | 5.0 | 9.1 | 10.0 | 60.0 | 59.0 | 98.3 |
| 2 | ТаБГ | 25.0 | 10.0 | 5.0 | 9.9 | 10.0 | 60.0 | 59.9 | 99.8 |
| 3 | НБББГ | 23.9 | 10.0 | - | 9.6 | 10.0 | 55.0 | 53.5 | 97.2 |
| 4 | СБГ | 22.8 | 9.9 | 5.0 | 9.7 | 10.0 | 60.0 | 57.7 | 96.1 |
| 5 | ХСХОГ | 25.0 | 10.0 | - | 9.2 | 10.0 | 55.0 | 54.2 | 98.5 |
| 6 | СТСГ | 25.0 | 10.0 | - | 9.3 | 10.0 | 55.0 | 54.3 | 98.7 |
| 7 | ТЗУГ | 25.0 | 9.5 | 5.0 | 9.5 | 10.0 | 60.0 | 59.0 | 98.3 |
| 8 | ТСГ | 25.0 | 9.9 | 5.0 | 9.0 | 10.0 | 60.0 | 59.5 | 99.1 |
| 9 | СХЭУГ | 25.0 | 10.0 | 5.0 | 9.9 | 10.0 | 60.0 | 59.9 | 99.8 |
| 10 | ХЭЗГ | 25.0 | 9.9 | - | 9.5 | 10.0 | 55.0 | 54.6 | 99.2 |
| **Нийт дундаж** | | | | | | | **580** | **571.6** | **98.5** |




Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн А/116 дугаар тушаалын хавсралтаар баталсан **“Яамны дотоод бүтцийн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх журам”**-ын дагуу яамны газруудын 2024 оны 11 дүгээр сарын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ, хийж, үр дүнг үнэлэхэд дунджаар **98.5 хувьтай** байна.
*/Дэлгэрэнгүйг хавсралт 1-ээс үзнэ үү/*

## 31 Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт (11 сар)

**98.7**
хувь

| Газар | Нийт арга хэмжээ | Хэрэгжилтийн хувь | | | | | | | Биелэлтийн хувь | Оноо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 100 | 90 | 70 | 50 | 30 | 0 | - | | |
| НБББГ | 15 | 12 | - | 2 | - | - | - | 1 | 95.7% | 23.9 |
| СБГ | 29 | 21 | - | - | - | - | 2 | 6 | 91.3% | 22.8 |
| ХСХОГ | 25 | 23 | - | - | - | - | - | 2 | 100.0% | 25.0 |
| СТСГ | 2 | 2 | - | - | - | - | - | - | 100.0% | 25.0 |
| ТЗУГ | 37 | 37 | - | - | - | - | - | - | 100.0% | 25.0 |
| ТСГ | 30 | 29 | - | - | - | - | - | 1 | 100.0% | 25.0 |
| СХЭУГ | 19 | 19 | - | - | - | - | - | - | 100.0% | 25.0 |
| ХЭЗГ | 14 | 12 | - | | - | | - | 2 | 100.0% | 25.0 |
| ТБТГ | 19 | 19 | - | - | - | - | - | - | 100.0% | 25.0 |
| ТаБГ | 3 | 2 | - | - | - | - | - | 1 | 100.0% | 25.0 |
| **НИЙТ** | **193** | **171** | **0** | **2** | **0** | **0** | **2** | **13** | **98.7%** | **24.7** |

Сангийн яам 2024 оны 4 дүгээр сард нийт **193** ажил төлөвлөснөөс хэрэгжилт яамны дунджаар **98.7** хувьтай байна. Сарын төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээгээр ТБТГ, ТаБГ, ХСХОГ, СТСГ, СХЭУГ, ХЭЗГ, СХЭУГ, ТЗУГ тус бүр 100 хувиар тэргүүлж байна

НБББГ-ын 2 ажил 70 хувийн, СБГ-ын 2 ажил 0 хувийн үнэлгээтэй байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээнд хамруулаагүй 17 ажил байгаа ба үүнд яам, газрын удирдлагын шийдвэр, бусад байгууллагын үйл ажиллагаанаас хамааралтайгаар цуцлагдсан, хойшлогдсон, асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлт ирээгүй зэрэг шалтгааны улмаас хэрэгжих боломжгүй болсон ажлууд багтаж байна. *Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос үзнэ үү/*

## Албан бичгийн шийдвэрлэлт (11 сар)

**99.2** хувь

Сангийн яаманд 2024 оны 11 дүгээр сарын байдлаар нийт 2’441 албан бичиг ирснээс 2’844 бичгийн хариуг хугацаанд нь өгсөн хугацаа хоцорч боловсруулж байгаа 5, хугацаа хоцорч боловсруулж дууссан 6 албан бичиг байна. Албан бичгийн шийдвэрлэлт **99.2% хувьтай** байлаа. */Дэлгэрэнгүйг хавсралт 3-аас үзнэ үү/.*

| Нэр | | Боловсруулж байгаа | Боловсруул-сан | Боловсруул-сан (Хоцорсон) | Боловсруулж байгаа хоцорсон | Нийт | Хувь | Оноо |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | ТБТГ | 54 | 88 | 1 | | 143 | 98.9% | 9.9 |
| 2 | ТБГ | 22 | 49 | | | 71 | 100.0% | 10.0 |
| 3 | НБББГ | 17 | 11 | | | 28 | 100.0% | 10.0 |
| 4 | СБГ | 42 | 171 | 1 | | 214 | 99.4% | 9.9 |
| 5 | ХСХОГ | 206 | 557 | | 2 | 765 | 99.6% | 10.0 |
| 6 | СТСГ | 3 | 3 | | | 6 | 100.0% | 10.0 |
| 7 | ТЗУГ | 41 | 60 | 2 | 1 | 104 | 95.2% | 9.5 |
| 8 | ТСГ | 243 | 551 | 1 | 2 | 797 | 99.5% | 9.9 |
| 9 | СХЭУГ | 3 | 20 | | | 23 | 100.0% | 10.0 |
| 10 | ХЭЗГ | 115 | 174 | | 1 | 290 | 99.4% | 9.9 |
| **НИЙТ** | | **746** | **1 684** | **5** | **6** | **2 441** | **99.2%** | **9.9** |

## Шуурхай үүрэг даалгаврын биелэлт (11 сар)

**100.0**
хувь

Яамны 2024 оны 11 дүгээр сарын 04, 11, 18 -ны өдрүүдийн шуурхай хуралдаанаар ТНБД нийт **9 үүрэг даалгаврыг** яамны газруудад өгсөн бөгөөд хэрэгжилтийн явц 2024 оны 11 дүгээр сарын эцсийн байдлаар **100.0 хувьтай** байв. */Шуурхай үүрэг даалгаврын биелэлтийг хавсралт 4-өөс үзнэ үү/.*

| № | Хариуцсан газар | Шуурхай үүрэг даалгаврын тоо /давхардсан тоогоор/ | Үнэлгээний дундаж | Авах оноо | Авсан оноо |
|---|---|---|---|---|---|
| 1 | ТБТГ | 3 | 100.0% | 5.0 | 5.0 |
| 2 | ТаБГ | 2 | 100.0% | 5.0 | 5.0 |
| 3 | НБББГ | - | - | - | - |
| 4 | СБГ | 1 | 100.0% | 5.0 | 5.0 |
| 5 | ХСХОГ | - | - | - | - |
| 6 | СТСГ | - | - | - | - |
| 7 | ТЗУГ | 3 | 100.0% | 5.0 | 5.0 |
| 8 | ТСГ | 2 | 100.0% | 5.0 | 5.0 |
| 9 | СХЭУГ | 1 | - | - | - |
| 10 | ХЭЗГ | - | - | - | - |
| **НИЙТ** | | **9** | **100.0%** | **100.0%** | 5.0 |

## Ажлын цаг ашиглалт (11 сар)

**94.98**
хувь

Яамны цаг бүртгэлийн системээс авсан мэдээллээр ажлын цаг ашиглалт 2024 оны 11 дүгээр сарын байдлаар дунджаар **94.98 хувьтай** байна.

| № | Дотоод бүтцийн нэгж | Ажлын цаг ашиглалтын хувь | Авах оноо | Авсан оноо |
|---|---|---|---|---|
| 1 | ТБТГ | 90.86% | 10.0 | 9.1 |
| 2 | ТаБГ | 99.70% | 10.0 | 9.9 |
| 3 | НБББГ | 96.41% | 10.0 | 9.6 |
| 4 | СБГ | 97.46% | 10.0 | 9.7 |
| 5 | ХСХОГ | 92.01% | 10.0 | 9.2 |
| 6 | СТСГ | 93.33% | 10.0 | 9.3 |
| 7 | ТЗУГ | 95.43% | 10.0 | 9.5 |
| 8 | ТСГ | 90.41% | 10.0 | 9.0 |
| 9 | СХЭУГ | 99.07% | 10.0 | 9.9 |
| 10 | ХЭЗГ | 97.78% | 10.0 | 9.7 |
| **НИЙТ** | | **95.25%** | **10.0** | **9.5** |

Мөн 2024 оны 11 дүгээр сард **200 минутаас дээш хоцролттой** яамны **5** газрын нийт **11** албан хаагчид байна. Үүнд:

- ХСХОГ-ын Н. Сансармаа
- СТСГ-ын З.Анар /4 сар дараалан хоцорсон/, Б.Бодьрагчаа
- ТСГ-ын Ч. Цэдэндорж /5 сар дараалан хоцорсон/, Б. Цагаанцэцэг, Н. Саруул, Т.Сайхантөгс
- ХЭЗГ-ын Б.Зоригтбаатар /2 сар дараалан хоцорсон/, Ч.Баярмаа
- ТЗУГ-ын А. Энхтуул, Г.Гүндалай

## Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал (11 сар)

**100.0** хувь

Яамны холбогдох газрууд яамны эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалт, үйлчилгээ, мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, заавар, сангийн яамнаас олгож байгаа тусгай зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг яамны цахим хуудсанд байршуулж, шинэчлэн ажилласан байна. 2024 оны 11 дүгээр сарын байдлаар хэрэгжилт **100 хувьтай** байна. /Дэлгэрэнгүйг хавсралт 5-аас үзнэ үү/

| № | Цахим хуудсанд мэдээлэл оруулсан газрууд | Үнэлгээ | Авах оноо | Авсан оноо |
|---|---|---|---|---|
| 1 | ТБТГ | 100.0% | 10.0 | 10.0 |
| 2 | ТаБГ | 100.0% | 10.0 | 10.0 |
| 3 | НБББГ | 100.0% | 10.0 | 10.0 |
| 4 | СБГ | 100.0% | 10.0 | 10.0 |
| 5 | ХСХОГ | 100.0% | 10.0 | 10.0 |
| 6 | СТСГ | 100.0% | 10.0 | 10.0 |
| 7 | ТЗУГ | 100.0% | 10.0 | 10.0 |
| 8 | ТСГ | 100.0% | 10.0 | 10.0 |
| 9 | СХЭУГ | 100.0% | 10.0 | 10.0 |
| 10 | ХЭЗГ | 100.0% | 10.0 | 10.0 |
| **НИЙТ** | | **100.0%** | **10.0** | **10.0** |

## Дүгнэлт

1. Яамны 2024 оны 11 дүгээр сард нийт төлөвлөсөн 193 ажлаас 88.6 хувийг бүрэн хэрэгжүүлж ажилласан ба 2.07 хувийг хэрэгжүүлж дуусаагүй (үүнд: 4 ажил) байна.

2. Газруудын албан бичиг шийдвэрлэлтийн байдал 97.2 хувьтай байна. 11 дүгээр сард хариу өгөх хугацааг хоцроож шийдвэрлэсэн 6, хоцроон боловсруулж буй 5 албан бичиг байна.

3. 2024 оны 11 дүгээр сарын яамны газруудын ажлын цаг ашиглалт дунджаар 94.98 хувьтай байна.



## Зөвлөмж

1. 2024 оны 11 дүгээр сарын төлөвлөгөөнд гүйцэтгэхээр төлөвлөсөн болович хэрэгжилтийн шатанд буюу удаашралтай байгаа ажлуудыг газрууд дараа сарын төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж дуусгах;

2. Сарын биелэлтийг тайлагнахдаа хийсэн ажлын үр дүн, ач холбогдлыг бүрэн гүйцэд, товч, тодорхой бичиж, огноо, албан бичгийн дугаар зэрэг баримт мэдээллийг оруулж, шаардлагатай тайлан мэдээллийг хавсаргаж, дараа сарын 5-ны дотор тайлагнаж хэвших;

3. Албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж буй эсэхэд газар, хэлтсийн удирдлагаас тавих, хяналтыг сайжруулах, хариу өгсөн, шийдвэрлэсэн тухай мэдээллийг албан бичгийн бүртгэлийн системд тухай бүрд нь оруулж хэвших;

4. Шуурхай үүрэг, даалгаврын биелэлтийг газрууд долоо хоног бүрийн Пүрэв гарагт хяналт-шинжилгээ, үнэлгээний ЛМ цахим системд хугацаанд нь тогтмол тайлагнаж хэвших;

5. Газар, хэлтсийн ажлын цаг ашиглалтыг сайжруулахад газар, хэлтсийн удирдлагаас тавих, хяналтыг сайжруулах.

6. Газрын сарын төлөвлөгөөг хугацаанд нь боловсруулж, батлуулахад газар, хэлтсийн удирдлагаас тавих, хяналтыг сайжруулах.

## ХАВСРАЛТ

**Хавсралт 1. Газруудын үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээ (11 сар)**

| № | Газар | Сарын төлөвлөгөө | | Албан бичиг шийдвэрлэлт | | Ш/Ү даалгаврын биелэлт | | Ажлын цаг ашиглалт | | Ү/а-ны нээлттэй ил тод байдал | | НИЙТ | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Авах оноо | Авсан оноо | Авах оноо | Авсан оноо | Авах оноо | Авсан оноо | Авах оноо | Авсан оноо | Авах оноо | Авсан оноо | Авах оноо | Авсан оноо | Эзлэх хувь |
| 1 | ТБТГ | 25.0 | 25.0 | 10.0 | 9.9 | 5.0 | 5.0 | 10.0 | 9.1 | 10.0 | 10.0 | 60.0 | 59.0 | 98.3 |
| 2 | ТаБГ | 25.0 | 25.0 | 10.0 | 10.0 | 5.0 | 5.0 | 10.0 | 9.9 | 10.0 | 10.0 | 60.0 | 59.9 | 99.8 |
| 3 | НБББГ | 25.0 | 23.9 | 10.0 | 10.0 | - | - | 10.0 | 9.6 | 10.0 | 10.0 | 55.0 | 53.5 | 97.2 |
| 4 | СБГ | 25.0 | 22.8 | 10.0 | 9.9 | 5.0 | 5.0 | 10.0 | 9.7 | 10.0 | 10.0 | 60.0 | 57.7 | 96.1 |
| 5 | ХСХОГ | 25.0 | 25.0 | 10.0 | 10.0 | - | - | 10.0 | 9.2 | 10.0 | 10.0 | 55.0 | 54.2 | 98.5 |
| 6 | СТСГ | 25.0 | 25.0 | 10.0 | 10.0 | - | - | 10.0 | 9.3 | 10.0 | 10.0 | 55.0 | 54.3 | 98.7 |
| 7 | ТЗУГ | 25.0 | 25.0 | 10.0 | 9.5 | 5.0 | 5.0 | 10.0 | 9.5 | 10.0 | 10.0 | 60.0 | 59.0 | 98.3 |
| 8 | ТСГ | 25.0 | 25.0 | 10.0 | 9.9 | 5.0 | 5.0 | 10.0 | 9.0 | 10.0 | 10.0 | 60.0 | 59.5 | 99.1 |
| 9 | СХЭУГ | 25.0 | 25.0 | 10.0 | 10.0 | 5.0 | 5.0 | 10.0 | 9.9 | 10.0 | 10.0 | 60.0 | 59.9 | 99.8 |
| 10 | ХЭЗГ | 25.0 | 25.0 | 10.0 | 9.9 | - | - | 10.0 | 9.7 | 10.0 | 10.0 | 55.0 | 54.6 | 99.2 |
| | **НИЙТ** | **25.0** | **24.7** | **10.0** | **9.9** | **5.0** | **5.0** | **10.0** | **9.5** | **10.0** | **10.0** | **580** | **571.6** | **98.5** |

**Хавсралт 2. Сарын төлөвлөгөөнөөс хэрэгжүүлээгүй болон хэрэгжиж дуусаагүй, удаашралтай байгаа нийт 4, үнэлгээнд хамруулаагүй 13 ажил байна. Үүнд**:

***70 хувийн хэрэгжилттэй 2 ажил:***

.

*Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар:*

1. Улс төрийн намын тухай хуулийн 36.5.-д заасан намын санхүүгийн тайлангийн журмыг сонгуулийн төв байгууллагатай хамтран боловсруулж, батлуулах (Д. Дариймаа, Б. Амаржаргал) Тайлбар: Хэрэгжилтийн шатанд байна.
2. Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлан гаргах журмыг шинэчлэн боловсруулж, Сангийн сайдын тушаалаар батлуулах (Д. Дариймаа, Б. Амаржаргал, Э. Буянхишиг) Тайлбар: Хэрэгжилтийн шатанд байна.

***0 хувийн хэрэгжилттэй 2 ажил:***

*Санхүүгийн бодлогын газар:*

1. Сангийн сайдын Монгол Улсад шинээр томилогдсон Элчин сайд болон суурин төлөөлөгч нартай хийх танилцах уулзалтыг зохион байгуулах (Э. Мөнхбилэг) Тайлбар: Уулзалтыг зохион байгуулаагүй.
2. Санхүүгийн түрээсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх (Б. Амарбаясгалан)
   Тайлбар: Зорилтот түвшинд хүрээгүй

***Сарын төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд үнэлгээнд хамрагдаагүй 17 ажил:***

*Татварын бодлогын газар*:

1. Монгол Улсын Олон Улсын гэрээний хүрээнд хүмүүнлэгийн болон буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр импортолсон барааг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлүүлэх хүсэлтийг хянаж бүртгэх (Т. Анхбаяр, Ч. Мөнхшүр)
   Тайлбар: Тайлант хугацаанд хүсэлт ирүүлээгүй байна.

*Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар:*

1. Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 21.1.2.-т заасны дагуу Үнэлгээний хуулийн этгээдэд хийх чанарын хяналтын журмыг боловсруулж Сангийн сайдын тушаалаар батлуулах ( О.Бавуубал, Д. Дариймаа)
   Тайлбар: 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Хөрөнгийн үнэлгээний олон улсын шинэ стандарт мөрдөгдөх болсон тул дахин боловсруулах болсон.

*Санхүүгийн бодлогын газар:*

1. ТЕЗ нараас ирүүлсэн Засгийн газрын тусгай санг байгуулах, татан буулгах, өөрчлөн зохион байгуулах, тусгай сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих асуудлыг журамлах асуудлаар ирүүлсэн санал, шийдвэрийн төслийг хянаж, дэмжлэг үзүүлэх, шаардлагатай тохиолдолд Засгийн газрын

тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасан дүгнэлтийн төслийг боловсруулан удирдлагад танилцуулах (Н.Хадбаатар, Ж. Золбаяр)
Тайлбар: Засгийн газрын тусгай санг байгуулах, татан буулгах, өөрчлөн зохион байгуулах, тусгай сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих асуудлаар санал шийдвэр ирээгүй Засгийн газрын өрийн баталгаа гаргах төсөл, арга хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийлгэх, баталгаа гаргах ажлыг зохион байгуулах (Д.Хашчулуу, М.Баасандорж)
Тайлбар: Тухайн сард хүсэлт ирүүлээгүй болно

2. Засгийн газрын өрийн баталгаа гаргахаар хүсэлт ирүүлсэн төслийн эрсдэлийн үнэлгээг боловсруулж, Үндэсний аудитын газарт хүргүүлж, баталгаа гаргах (Д.Хашчулуу, М.Баасандорж)
   Тайлбар:Тухайн сард Засгийн газрын өрийн баталгаа гаргуулах хүсэлт ирүүлээгүй болно
3. Өрийн удирдлагын тухай хуулийн 16.2, 17.1, 18.1-д заасны дагуу шинээр зээллэг хийх, өрийн зохицуулалтын аливаа үйл ажиллагаа нь Өрийн удирдлагын стратегийн баримт бичиг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн хязгаар, Тухайн жилийн зээллэгийн дээд хэмжээнд нийцэж байгаа эсэх талаар санал, дүгнэлт гаргах ( Д. Хашчулуу, М. Баасандорж)
   Тайлбар: Тухайн сард шинээр зээл авах хүсэлт ирүүлээгүй болно.
4. Монгол Улсын Засгийн газар болон бусад орны Засгийн газар хоорондын комиссын хуралдааны мөрөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний төсөлд тус яамны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах ажлуудад холбогдох газар, хэлтсүүдийн саналыг авч хүргүүлэх (Э. Мөнхбилэг)
   Тайлбар: Гадаад харилцааны яамнаас төлөвлөгөөний төслийг боловсруулж ирүүлээгүй байна.
5. Монгол Улсын Засгийн газар болон түнш орнуудын Засгийн газар хоорондын комиссын хуралдааны төлөвлөгөөнд санал өгөх, биелэлтийг хангаж ажиллах (Э. Мөнхбилэг)
   Тайлбар: Тухайн сард батлагдсан төлөвлөгөө гараагүй болно.
6. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газрын (ТИКА) хооронд буцалтгүй тусламжийн хүрээнд шинээр хэрэгжүүлэх төслийн саналыг судлан шийдвэрлэж, туркийн талд хүргүүлэх (Т. Энхсаруул)
   Тайлбар: Тухайн сард төслийн санал ирүүлээгүй болно.

*<u>Хууль, эрх зүйн газар:</u>*

1. Ажил гүйцэтгүүлэх тендерийн ашиглалтын хугацааны өртөг тооцох аргачлал, заавар боловсруулж, Сангийн сайдын тушаалаар батлуулах( Ч.Баярмаа, Д.Гантулга)
   Тайлбар: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажил хийгдэж байгаатай холбогдуулан тус ажил хойшлогдсон болно.
2. Төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хүний эрхийн шалгуур үзүүлэлтийг харгалзан баримтлах удирдамжийг боловсруулах (Л. Амгалан, Д. Гантулга)
   Тайлбар: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажил хийгдэж байгаатай холбогдуулан хойшилсон.

*Төрийн сангийн газар:*

1. Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заалврын төсөлд холбогдох газруудаас санал авах. ( Л. Нямсүрэн)
   Тайлбар: Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавврын төсөлд 21 аймаг, нийслэл 9 дүүргээс судалгаа авч, төслийг шинэчлэн боловсруулж ажиллалаа. Газар дотроо заавврын төслийг хэлэлцүүлсэн. Гэвч тус заавар нь Хууль эрх зүйн хувьд бусад хууль эрх зүйн акттай зөрчилдөх тул Төрийн албаны зөвлөлд хандан ажлын байрны тодорхойлолтод тусгуулахаар ажиллаж байна.

*Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газар:*

1. Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газарт агаараас аврах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төслийн хоёрдугаар үе шатны хэрэгжилтийг хангах. (Э. Дөлгөөн)
   Тайлбар: БНФУ-ын нэн хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж буй “Онцгой байдлын байгууллагад агаараас аврах нэгж байгуулах, нисдэг тэрэг, гал унтраах тусгай зориулалтын автомашин нийлүүлэх төсөл"-ийн 2 дугаар үе шатны хүрээнд 11 дүгээр сард Сангийн яаманд санхүүжилт шийдвэрлүүлэх тухай хүсэлт ирээгүй байна.
2. Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төслийн хэрэгжилтийг хангах. (Э. Дөлгөөн)
   Тайлбар: БНФУ-ын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төсөл"-ийн хүрээнд 11 дүгээр сард Сангийн яаманд санхүүжилт шийдвэрлүүлэх тухай хүсэлт ирээгүй байна.

## Хавсралт 3. Хугацаа хоцорч боловсруулж байгаа болон хугацаа хоцорч боловсруулж дууссан албан бичгийн жагсаалт (11 сар)

*3.1.Хугацаа хоцорч боловсруулсан албан бичиг*

| № | Бүрт-гэлийн дугаар | АБ дугаар | Ирсэн огноо | Дуусах огноо | А/Б хаасан хугацаа | Боловс-руулсан хоног | Хаанаас | Товч утга | Газар | Мэргэжилтэн | Хариутай эсэх | Статус | АБ төрөл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 71660 | ХЗ/15 | 11/6/2024 | 11/19/2024 4:00:00 PM | - | 22 | Монголын хөрөнгийн бирж ХК ийн хяналтын зөвлөл Мөнхзул Ц | Санал шаардлага хүргүүлэх тухай | СБГ | Бат-Эрдэнэ Шарав | Тийм | Боловсруулж байгаа (Хоцорсон) | Албан бичиг |
| 2 | 71286 | 01/1074 | 11/4/2024 | 11/17/2024 4:00:00 PM | - | 24 | Гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд Энх-Амгалан Л | ЯАРАЛТАЙ: Журам батлах тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал ирүүлэх тухай | ТБТГ | Содномдаржаа Ваанчиг-Арслан | Тийм | Боловсруулж байгаа (Хоцорсон) | Албан бичиг |
| 3 | 71971 | 260 | 11/8/2024 | 11/21/2024 4:00:00 PM | - | 20 | Жендэрийн үндэсний хороо Энхбаяр Т | Сургалтад хамруулах тухай | ТЗУГ | Болормаа Балжинням | Үгүй | Боловсруулж байгаа (Хоцорсон) | Албан бичиг |
| 4 | 71744 | 01/8426 | 11/7/2024 | 11/20/2024 4:00:00 PM | - | 21 | Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх Одмаа Ц | Нотлох баримт ирүүлэх тухай | ТЗУГ | Хүдэрням Надмид | Тийм | Боловсруулж байгаа (Хоцорсон) | Албан бичиг |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | 72042 | 03/1600 | 11/8/2024 | 11/21/2024 4:00:00 PM | - | 20 | С.Батболд, Зам, тээврийн хөгжлийн Яам | Эрх нээлгэх тухай /Ялгуусан ХХК 78,746,883.75/ | ТСГ | Сувд Батдэлгэр | Үгүй | Боловсруулж байгаа (Хоцорсон) | Цахим албан бичиг |

*3.2 Хугацаа хоцроон боловсруулж байгаа албан бичгийн жагсаалт*

| № | Бүрт-гэлийн дугаар | АБ дугаар | Ирсэн огноо | Дуусах огноо | А/Б хаасан хугацаа | Боловс-руулсан хоног | Хаанаас | Товч утга | Газар | Мэргэжилтэн | Хариутай эсэх | Статус | АБ төрөл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 71171 | 1/104 | 11/1/2024 | 11/14/2024 4:00:00 PM | 2024-11-17T16:00:00Z | 17 | Блейз тек ХХК Даваа-Очир Б | Тендерийн гомдол гаргах тухай | ХЭЗГ | Зоригтбаатар Бямбасүрэн | Үгүй | Боловсруулсан (Хоцорсон) | Албан бичиг |
| 2 | 71622 | 01/2323 | 11/6/2024 | 11/19/2024 4:00:00 PM | 2024-11-24T16:00:00Z | 19 | Монгол улсын тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг хөгжлийн сайд Гантөмөр Л | ЯАРАЛТАЙ: Журам батлах тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал ирүүлэх тухай | ХСХОГ | Ёндонсамбуу Ембүү | Тийм | Боловсруулсан (Хоцорсон) | Албан бичиг |
| 3 | 72149 | 11/11-01 | 11/11/2024 | 11/24/2024 4:00:00 PM | 2024-11-27T16:00:00Z | 17 | Тэмээн ХХК Сэрээнэн Ч | Хүсэлт гаргах тухай | ХСХОГ | Хонгор Түмэнбаяр | Үгүй | Боловсруулсан (Хоцорсон) | Албан бичиг |
| 4 | 71227 | 216 | 11/1/2024 | 11/22/2024 4:00:00 PM | 2024-11-24T16:00:00Z | 24 | Ахмад настны үндэсний төв Эрдэнэхүү Л | Зарцуулах эрх нээлгэх тухай | ТСГ | Цагаанцэцэг Болдбаатар | Үгүй | Боловсруулсан (Хоцорсон) | Албан бичиг |
| 5 | 71934 | 16/5339 | 11/8/2024 | 11/21/2024 4:00:00 PM | 2024-11-24T16:00:00Z | 17 | Гадаад харилцааны яам Мөнхтүшиг Л | Хүсэлт уламжлах тухай | ТСГ | Адилчимэг Алтангэрэл | Тийм | Боловсруулсан (Хоцорсон) | Албан бичиг |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | 71270 | 01-1/4508 | 11/4/2024 | 11/17/2024 4:00:00 PM | 2024-11-20T16:00:00Z | 17 | Гаалийн ерөнхий газар Хосбаяр Б | Дэмжлэг хүсэх тухай | ТЗУГ | Баянмөнх Зандаръяа | Үгүй | Боловсруулсан (Хоцорсон) | Албан бичиг |

## Хавсралт 4. Шуурхай үүрэг даалгаврын тайлан (11 сар)

| № | Үүрэг, даалгавар өгсөн албан тушаалтан | Өгсөн үүрэг, даалгавар | Үүрэг, даалгавар өгсөн огноо | Хариуцах газар | Хэрэгжилтийн явц | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | ТНБД | Монгол Улсын 2025 оны төсвийн төслийн 2 дугаар хэлэлцүүлэг дууссан. Энэ 7 хоногт болох хэлэлцүүлэгт анхаарах, төсвийн тоог маш сайн хянах, редакц сайн хийх. Соёлын яамны төсвийн төсөлд тусгасан 18,3 тэрбум төгрөгийн асуудал үүссэн. УИХ-ын гишүүдээс асуулт ирсэн. Хэзээнээс төсөв дээр тавьсан, хэрхэн хянасан, ямар хууль тогтоомжийн хүрээнд оруулсан гэх мэт тодруулах, тайлбар бэлдэх. | 2024.11.04 | ТБТГ | Монгол Улсын 2025 оны төсвийн төслийн хэлэлцүүлэгт бэлтгэж, шаардлагатай тооцооллыг хийсэн. Мөн гишүүдээс ирсэн асуултын дагуу тодруулга, тайлбар бэлтгээд байна. Соёлын яамны төсвийн төсөлд тусгасан 18.3 тэрбум төгрөгийн хувьд: Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт "Үндэсний соёлын агуулгыг түгээх, таниулах болон соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчийн бизнесийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын иргэнд соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичгийг төрөөс үнэ төлбөргүй олгоно." гэж 8.3-т "Энэ хуулийн 8.2 дахь хэсэгт "соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичгийг 16-18 насны иргэнд жил бүр олгоно." гэж заасны дагуу 2025 оны төсвийн төсөлд жилд 1 удаа 1 хүүхдэд 100.0 мянган төгрөгийн эрхийн бичиг бүхий ваучер олгохоор нийт 183,259 хүүхдэд олгох 18.3 тэрбум төгрөгийг тусгасан. | 100% |
| 2 | ТНБД | Засгийн газрын мөнгөн хөрөнгийн асуудалд анхаарах. Яаралтай шийдвэр гаргах. | 2024.11.04 | ТСГ | Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн 2024 оны ХБГ болон 2025 оны 1 дүгээр улирлын ХБГ-ийг 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр ТНБД, газрын дарга нарт танилцуулсан болно. ТНБД-ын зүгээс 2024 оны төсвийн жил дуустал ТСГ, ТБТГ-т төсвийн тусгай шаардлагаа анхаарах, ХСХОГ-т барьцаа дансны ХО-ын үлдэгдлийг цэгцлэх талаар анхаарч ажиллах чиглэл өгсөн | 100% |
| 3 | ТНБД | 2024 он дуусахад 2 сар үлдсэн. Сангийн сайдын хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн асуудал, Сангийн сайдын багц, үлдэгдэл санхүүжилтийн асуудлыг анхаарах. | 2024.11.04 | ТЗУГ | Сангийн яамны 2024 оны төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл, Сангийн сайдын 2024 оны хөрөнгө оруулалтын хүлээгдэж буй гүйцэтгэлийн талаар танилцуулга бэлтгэсэн. Удирдлагад танилцуулахад бэлэн болсон. | 100% |
| 4 | ТНБД | СХЭУГ яамны үйл ажиллагааны тайлан, үнэлгээнд анхаарах. Засгийн газрын Хяналт | 2024.11.11 | СХЭУГ | Яамны үйл ажиллагааны тайлан, үнэлгээнд анхааран ЗГХЭГ-аас тогтоосон хугацаанд тайланг хүргүүлэн ажиллаж байна. Тухайлбал, 11 сар эхэлснээс хойш Сангийн яамны “Төрийн албан | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | хэрэгжүүлэх газартай нягт хамтарч ажиллах. | | | хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд 2023 оны жилийн эцэс, 2024 оны эхний хагас жилийн байдлаар хийсэн ХШҮ-ний тайланг ТНБД-ын 2024 оны 11 сарын 08-ны өдрийн 03/9249 тоот албан бичгээр хүргүүлж ажилласан. | |
| 5 | ТНБД | 2024 он дуусах дөхөж байгаа тул Сангийн сайдын багцын гүйцэтгэл, мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг зөв тооцоход анхаарах. | 2024.11.11 | ТЗУГ, ТСГ | Сангийн сайдын 2024 оны төсөл арга хэмжээний бэлтгэл хангах төслийн хүрээнд санхүүжих төсөл арга хэмжээний жагсаалтыг үлдэгдлийг тооцож, яамны удирдлагад тухай бүр /өөрчлөлт орсон/ танилцуулж байна. | 100% |
| 6 | ТНБД | Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийг батлуулсан. Энэ 12 сардаа багтаан төсвийн тодотголыг боловсруулна. Урсгал зардлыг хэмнэх, халамжийг хэрхэн зөв зохицуулах талаар санал бэлтгэх. Удирдлагад танилцуулах. | 2024.11.11 | ТБТГ | 2025 оны төсвийн тухай хуульд тодотгол хийх чиглэлийг Улсын Их Хурлаас өгсөнтэй холбогдуулан 2025 оны төсвийн тодотголын саналыг бэлтгэн Сайдын зөвлөлд танилцуулан ажиллаж байна. | 100% |
| 7 | ТНБД | Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн үүрэг даалгавар дээр онцгой анхаарах | 2024.11.18 | ТаБГ | Монгол Улсын Ерөнхий сайдаас өгсөн үүрэг даалгавар дээр онцгой анхаарч, татварын бодлогын өнөөгийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлагын талаарх танилцуулгын агуулга, форматыг бэлтгэн ажиллаж байна. | 100% |
| 8 | ТНБД | Цахим орчинд гаалийн байцаагч нартай холбоотой мэдээлэл гарсан. Тус асуудлыг онцгой анхаарах, үндэслэлгүй явж байгаа мэдээд хурдан шуурхай хариу мэдэгдэл хийж ажиллах. | 2024.11.18 | ТЗУГ | Цахим орчинд гаалийн байцаагч нартай холбоотой мэдээлэл гарсантай холбогдуулан Авлигатай тэмцэх газарт Гаалийн ерөнхий газрын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 02/4849 тоот хүсэлт уламжлах тухай албан бичиг хүргүүлэн ажиллаж байна. Үүссэн асуудлаар 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Гаалийн ерөнхий газрын Хуулийн хэлтсийн дарга Ч.Тамираа хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгсөн. | 100% |
| 9 | ТНБД | Засгийн газрын 100 хоногийн үйл ажиллагааны хэрэгжилтийн танилцуулга ППД дээр анхаарах. Дараа 7 хоногийн шуурхай хуралд танилцуулах. | 2024.11.18 | СБГ, ТБТГ, ТаБГ | Засгийн газрын 100 хоногийн үйл ажиллагааны хэрэгжилтийн танилцуулгыг хийж бэлтгэсэн. Мөн ТБТГ, СБГ, ТаБГ-уудаас Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлагдсантай холбогдуулан 2024 онд багтаан хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний биелэлтийг хангаж, үр дүн гаргах зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 01 дүгээр албан даалгаварт тусгагдсан, Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хэмжээнүүдийн танилцуулгыг шинэчлэн гаргуулан мөн арга хэмжээнүүдийн нарийвчилсан төлөвлөгөөг гаргуулан сайдын тушаалаар батлуулахаар удирдлагаар хянуулж байна | |
| **ДУНДАЖ** | | | | | **100.0 %** | |

## Хавсралт 5. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал (11 сар)

| № | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Хариуцсан газар |
|---|---|---|---|
| | | Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал | |
| 1. | Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Яамны эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг яамны цахим хуудас болон бусад мэдээллийн хэрэгслээр тухай бүр олон нийтэд мэдээлэн ажилласан.<br>- Монгол Улсын Ерөнхий сайд Л. Оюун-Эрдэнэ 2024.11.14-ний өдөр Сангийн яаманд ажиллалаа. Сангийн сайд Б. Жавхлан төсвийн бодлого болон өмнөх жилүүдийн төсвийн орлого, ДНБ-ий өсөлт, өр зээлийн хэмжээ хэрхэн буурч байгаа талаарх харьцуулсан судалгааг танилцуулав. https://www.facebook.com/photo/?fbid=875924251397676&set=pcb.875927351397366<br>- Монгол Улсын Ерөнхий сайд Л. Оюун-Эрдэнэ, Сангийн сайд Б. Жавхлан болон холбогдох албаны хүмүүс 2024.11.14-ний өдөр Татварын ерөнхий газарт ажиллаж, ТЕГ-ын алба хаагчдын санал хүсэлтийг сонслоо. Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн татварын бодлого, шинэчлэлийн талаар эхлээд танилцуулав. https://www.facebook.com/photo/?fbid=875950904728344&set=pcb.875952011394900<br>- УИХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиудын төслийг эцэслэн баталлаа. Засгийн газар "Алсын хараа-2050", "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хөрөнгө оруулалт, бизнесийн орчныг сайжруулах, бүсчилсэн хөгжлийг дэмжих татвар, төсвийн бодлогыг хэрэгжүүлэх, авлигыг бууруулж, хүний эрх, засаглалыг сайжруулах зэрэг эрх зүйн 14 реформыг хийж, эдийн засгийн суурийг тэлж, хөгжлийг эрчимжүүлэхийн тулд 14 мега төслийг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай юм. https://www.facebook.com/photo/?fbid=871465131843588&set=pcb.871442998512468<br>- Moody's" агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "B2,тогтвортой" хэмээн үнэллээ. Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч "Moody's" агентлаг өнөөдөр /2024.11.18/ Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 9 жилийн дараа "B2, тогтвортой" болж сайжирсныг зарлалаа. Өмнөх сард олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч "Fitch" агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг "B+тогтвортой", "S&P" агентлаг "B+эерэг" гэж үнэлснээ дараалан зарлаж байсан юм.<br>https://www.facebook.com/photo?fbid=878485314474903&set=a.177530921237016<br>- Олон улсын Валютын сан 2024 оны 4 дүгээр сард Монгол Улсын эдийн засаг ирэх онд 6 хувиар өсөхөөр төсөөлж байсан бол 2024 оны 10 дугаар сард 7 хувь болгон нэмэгдүүлжээ. Ингэснээр ирэх онд Монгол Улс эдийн засгийн өсөлтөөрөө бүс нутгаа тэргүүлж байна. Ирэх оны эдийн засгийн өсөлтөд Оюутолгойн гүний уурхайн олборлолт эрчимжин зэсийн баяжмал дахь алт, зэсийн агууламж нэмэгдэж, нүүрсний экспорт өсөхийн зэрэгцээ 2025 оны төсвийн бодлогын үр нөлөө эергээр нөлөөлнө гэж үзээд ийнхүү дүгнэсэн байна. https://www.facebook.com/photo/?fbid=866615798995188&set=a.177530921237016<br>- Яамны зохион байгуулалтын бүтэц, нэгжийн мэдээллийг тогтмол шинэчлэн байршуулсан. | ТЗУГ |
| 2. | Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн | Яамны өргөдөл, гомдол хариуцсан ажилтны холбогдох мэдээлэл, утсыг /267246, 110/ яамны цахим хуудас болон 1 давхрын цахим самбарт байршуулсан.<br>Сангийн яаманд хандан Засгийн газрын 11-11 төвөөр дамжуулан 2024 оны 11 дүгээр сард нийт 11 өргөдөл санал хүсэл ирснийг яамны холбогдох газруудад хүргүүлж хариуг илгээсэн болно. | ТЗУГ |

| | | | |
|---|---|---|---|
| | нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | | |
| 3. | Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан хүндэт тэмдэг болон Сангийн яамны шагналыг олгох талаарх “Журам шинэчлэн батлах тухай” Сангийн сайдын 75 тоот тушаалыг яамны цахим хуудсанд нээлттэй байршуулсан. Журмын дагуу яамны шагналын цахим хуудсанд www.reward.mof.gov.mn төрийн байгууллага болон аж ахуй нэгж, байгууллагаас нийт 930 шагналын материал ирснийг хянан, Сангийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 211 тоот тушаалаар шагналыг олгов. http://reward.mof.gov.mn/Anketaccept | **ТЗУГ** |
| 4. | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | - Яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газраас яамны цахим хуудсанд сар бүрийн үнийн мэдээллийг тогтмол байршуулж байна. https://mof.gov.mn/article/entry/2024-1<br>- 2024 оны улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого, төсвийн нийт зардал, төсвийн хөрөнгө оруулалтын мэдээг сар бүр яамны цахим хуудсанд байршуулж, нийтэд ил тод мэдээлж байна. https://mof.gov.mn/<br>- 2024 оны 11 дүгээр сарын байдлаар тусгай зөвшөөрлийн цахим www.licence.mof.gov.mn системд 4 хуулийн этгээдээс аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгах хүсэлтийг ирүүлсэн байна. Хүсэлтийн дагуу тус 3 хуулийн этгээдийн аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатайгаар сунгалаа. Тусгай зөвшөөрлийн цахим систем (license.mn) | **ХЭЗГ**<br>Бусад газрууд |
| 5. | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах; | - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ын 11 дүгээр зүйлийн 11.8 дахь хэсэгт "Чанар ба үнийн хосолмол үнэлгээний шалгуурыг зөвхөн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад хэрэглэнэ." гэж заасны дагуу эм, эмнэлгийн хэрэгслийг ерөнхий гэрээний аргаар худалдан авах тендер шалгаруулалтын баримт бичгийн төсөлд санал авах тухай зарыг яамны цахим сайтад 2024 оны 7 дугаар сарын 30-ны өдөр байршуулсан болно. Төсөлтэй танилцаж холбогдох саналаа 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн өмнө Сангийн яамны Хууль, эрх зүйн газрын Худалдан авах ажиллагааны бодлогын хэлтэс, 267648, 267416, nomingerel_d@mof.gov.mn хаягт ирүүлэхийг хүсье. https://mof.gov.mn/article/entry/20240731 | |
| 6. | Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион | Байхгүй | |

| | | | |
|---|---|---|---|
| | байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх; | | |
| 7. | Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх; | Сангийн яамтай 2018 оноос хойш гэрээ байгуулан ажиллаж байгаа ТББ-ын мэдээллийг яамны цахим хуудсанд байршуулсан болно. https://mof.gov.mn/article/accounting/tbb-medeelel | **ТЗУГ** |
| 8. | Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | Сангийн яамны цахим хуудас /mof.gov.mn/-ны Ил тод хэсэгт Сангийн яамнаас олгодог дараах зөвшөөрлийн холбогдох мэдээллийг тогтмол мэдээлдэг болно. Үүнд:<br>• Эд мөнгөний хонжворт сугалаа эрхлэх тусгай зөвшөөрөл;<br>• Гаалийн зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл;<br>• Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл;<br>• Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл<br>• Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл;<br>• Үнэт цаас үйлдвэрлэх тусгай тусгай зөвшөөрөл. | **Бүх газрууд** |
| 9. | Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх; | Салбарын хэмжээнд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, өр төлбөр, зээл тусламжтай холбоотой мэдээллийг тухай бүр яамны цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлсэн. Үүнд:<br>- Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 82.2 сая ам.долларын санхүүжилттэй "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн 2 дах зээлийн хэлэлцээрт Сангийн сайд Б.Жавхлан, АХБ-ны Суурин төлөөлөгч Шаннон Көулин нар 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр гарын үсэг зурлаа. Тус төслийн зорилго нь эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг чанаржуулах, аймаг, дүүргийн эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, эрүүл мэндийн салбарын худалдан авах ажиллагаа болон санхүүгийн удирдлагын чадавхыг нэмэгдүүлэх юм. https://www.facebook.com/photo?fbid=879919984331436&set=pcb.879922777664490 | **СБГ** |

| | | | |
|---|---|---|---|
| 10. | Төсвийн жилд батлагдсан хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэл /сая.төгрөг/ | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1300 төсөл, арга хэмжээнд 3,384.4 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар Төсвийн ерөнхийлөн захирагч, Аймаг, Нийслэлийн Засаг дарга нараас ирүүлсэн нийт 2025 гүйцэтгэл, санхүүжилтийн хүсэлтийг албан бичгээр болон https://publicinvestment.gov.mn/ цахим системээр хүлээн авч, хянан баталгаажуулж 1,560.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. | ХСХОГ |
| 11. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүд, эдийн засгийн ангиллаар /хувиар/ | 2024 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1300 төсөл, арга хэмжээг эдийн засгийн ангиллаар Барилга байгууламж 68.7%, Их засвар 2,1%, Тоног төхөөрөмж 12%, ТЭЗҮ 1,4%-аар тус тус ангилан https://publicinvestment.gov.mn/ цахим системд ил тод байршуулсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960457247471 | ХСХОГ |
| 12. | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийн объектын төрөл /тоо/ | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 1300 төсөл, арга хэмжээг объектын төрлөөр ангилж https://publicinvestment.gov.mn/ цахим системд ил тод байршуулсан. | ХСХОГ |